

Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II үе

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК

2012 оны 6 дугаар сар



**Улаанбаатар
Цэвэр Агаар Санаачлага II үе**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2012 оны 6 дугаар сар



Улаанбаатар Цэвэр Агаар сан – II үе
Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

Цэвэр агаарын сангийн 2012 оны болон 2013-2015 төсвийн төсөөсөл

Огноо: 2012 оны 6 дугаар сар

Байгаль орчин, аялал жуулчлалын
яам

ЕСБХБ

БОАЖЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Цэвэр агаарын сангийн төсөв (2012, 2013-2015 он)

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
	2012.06.18	Булган, Онно	Пиет де Вилдт		
	2012.06.18	Булган, Онно	Пиет де Вилдт		

УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААР САНААЧЛАГА II

Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд хоол хүнс бэлтгэх, гэр сууцаа халаахдаа хэрэглэж байгаа зуух нь бүтээмж бага, мөн түлшний зориулалтаар ашиглаж буй нүүрсний чанар муу тул өвлийн улиралд агаарын бохирдлыг үүсгэдэг гол хүчин зүйл болж байна. Улаанбаатар хотын агаарын чанарын түвшин жилээс жилд буурч, хотын хүн амын эрүүл мэнд, улс орны эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх хандлага нэгэнт бий болжээ. Гэр хорооллын айлуудын ашиглаж буй зуухны загварыг сайжруулж, түүхий нүүрсийг шууд хэрэглэж байгааг шигшиж цэвэршүүлсэн, утаа ялгаруулалт багатай, үр ашигтай түлшээр солих нь Улаанбаатар хотыг хамарсан агаарын бохирдлын асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх арга зам, гарц болоод байна. 2008 оноос эхлэн Улаанбаатар хотын удирдлагууд түүхий нүүрс түлшэнд хэрэглэхийг хориглосон ч цэвэр түлшний хангамж хязгаарлагдмал, өртөг өндөр, мөн тухайн харилцааг зохицуулах хууль, эрхзүйн орчин тодорхой бус байсны улмаас тус хориг нь төдийлэн биелэлээ олоогүй юм. Олон улсын санхүүгийн байгууллагууд (цаашид “ОУСБ-ууд” гэх), хөгжлийн агентлагууд, хандивлагч байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын (цаашид “Засгийн газар” гэх) хүсэлтээр агаарын бохирдолд нөлөөлж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банк нь зуухыг шинэчлэн солих хөтөлбөрийг боловсруулахаар тохиролцсон бөгөөд Засгийн газрын зүгээс Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкинд (цаашид “ЕСБХБ” эсвэл “Банк” гэх) түлшийг шинэчлэн солих ажлын тодорхой хэсэгт тусламж үзүүлэх хүсэлт тавьсан. ЕСБХБ нь 2008 оны 09 дүгээр сараас түүхий нүүрсний хэрэглээг цэвэр, хор багатай түлшээр солих төлөвлөгөөг боловсруулахаар Засгийн газартай хамтран ажиллаж эхэлсэн юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд 2009 оны 06 дугаар сард Засгийн газарт өргөн мэдүүлсэн Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөнд (“Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө” гэх) тусгагдсан юм. Энэхүү төслийн 1 дүгээр үе шатны үр дүнгийн нэг хэсэг нь Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө нь түлшийг шинэчлэн, солихтой холбоотой, өөр хоорондоо харилцан уялдаа бүхий олон асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн цогц арга, аргачлалаас бүрдэнэ. 2010 оны 06 дугаар сард Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг Засгийн газар, Агаарын тухай багц хуулийг Монгол Улсын Парламентаар батласны дараа Банк төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэхүү бичиг баримт нь Засгийн газарт Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх Зөвлөх мэргэжилтнүүдэд зориулсан ажлын удирдамж болно.

АГУУЛГА

1	Товч дүгнэлт	7
2	Удиртгал	8
3	2012 оны төсөв	9
3.1	2012 оны төсөв боловсруулах үйл явц _____	9
3.2	Төсвийн төсөөллийг боловсруулахад анхаарсан асуудлууд: _____	9
3.3	Дүгнэлт _____	10
4	2013-2015 оны төсөв	11
4.1	2013-2015 оны төсөв боловсруулах үйл явц _____	11
4.2	2013-2015 оны Төсвийн төсөөллийг боловсруулахад анхаарсан асуудлууд: ____	11
4.3	Дүгнэлт _____	12
5	Зөвлөмж	13
5.1	Төсөв боловсруулахад цаашид анхаарах асуудлууд. ____ 13	Error! Bookmark not defined.
6	Хавсралт	13
6.1	2012 оны төсвийн төсөөлөл. _____	14
6.2	2013-2015 оны төсвийн төсөөлөл. _____	15

1 Товч дүгнэлт

Улаанбаатар Цэвэр Агаар санаачлага II төслийн баг нь Цэвэр агаарын сангийн 2012 оны болон 2013-2015 оны төсвийн төслийг бэлтгэх, боловсронгуй болгох ажлын даалгаврын 3.4.5-ын хүрээнд энэхүү тайланг бэлтгэсэн болно.

Цэвэр агаарын сан нь Засгийн газрын тусгай сангийн хувьд бие даасан сан хэдий ч Төсвийн ерөнхийлөн захирагч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд байх тул уг сангийн төсөв нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцад багтаж батлагддаг байна.

Улаанбаатар Цэвэр Агаар санаачлага II төслийн багийн ажил эхлэх үед Цэвэр агаарын сангийн 2012 оны төсөв нь УИХ-д өргөн баригдсан үе байсан. Хэдий ийм боловч төслийн баг Цэвэр агаарын сангийн 2012 оны төсвийн хэмжээ ямар байж болох талаар судалгаа хийж, уг судалгаанд тулгуурлаж энэхүү 2012 оны төсвийн төслийг бэлтгэсэн болно.

Цэвэр агаарын сангийн 2012 оны төсөв нь энэхүү төслийн хүрээнд 31.2 тэрбум төгрөг байхаар тооцоологдсон нь уг сангийн 2012 оны батлагдсан төсвөөс 0.2 тэрбум төгрөгөөр илүү байгаа юм.

Цэвэр агаарын сангийн 2013-2015 оны төсвийн төсөөлөл нь нийт 220.7 тэрбум төгрөгийг уг сангийн ирэх 3 жилийн үйл ажиллагаанд зарцуулагдахаар тооцоолсон болно.

Энэхүү Улаанбаатар Цэвэр Агаар санаачлага II төслийн багаас тооцоолон гаргасан төсөв, төсөв боловсруулах явц, төсөл боловсруулахад анхаарал зүйлс зэрэг нь тус сангийн хувьд дараа дараагийн жилүүдэд төсвийг бэлтгэж, харьялах шатанд танилцуулж батлагдахад нь гарын авлага болоход оршино.

2 Удиртгал

Цэвэр агаарын сан нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Монгол Улсын Засгийн газрын тусгай сан юм.

Уг сан нь 2010 онд байгуулагдсан бөгөөд үндсэн зорилго нь агаарын бохирдлыг бууруулах, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагаа явуулах юм.

Засгийн газрын тусгай сангийн хувьд жил бүрийн үйл ажиллагааны зардал буюу төсөв нь төрийн бусад байгууллагуудын адил өөрийн харьяа яамны сайдын багцад багтаж батлагддаг байна.

Төслийн багийн хувьд тус сангийн 2012 оны төсвийг боловсруулахдаа УИХ-аас батлагдсан төсвийг суурь төсөв болгон, Цэвэр агаарын сангийн зохион байгуулалт, үйл ажиллагааны цар хүрээнд хийсэн дүн шинжилгээнд тулгаарлаж төсвийн төсөөллийг боловсруулсан болно.

Цэвэр агаарын сангийн 2013-2015 оны төсвийн төсөөллийг боловсруулахдаа 2012 оны төсвийн төсөөллийг суурь болгосон. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн дүнг тодорхойлохдоо УИХ-аас гаргасан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, Засгийн газрын бодлогод төлөвлөгөөнд нийцүүлсэн гаргасан БОАЖЯ-ны “Дунд хугацааны зорилт, хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төсөөлөл”-д тулгаарлан 2013-2015 оны төсвийн төсөөллийг бэлтгэсэн.

Цаашид 2012 оны сонгуулын үйл ажиллагаатай холбогдож, шинээр байгуулагдах Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдаж Цэвэр агаарын сангийн 2013-2015 оны төсвийн төсөл тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж магадлал байгааг төслийн багийнхан тэмдэглэхийг хүсэж байна.

Цэвэр агаарын сангийн 2012-2013 оны онуудын төсвийн төслийг боловсруулах үйл явцын үед учирч байсан гол бэрхшээл бол тус сангийн хувьд Удирдах зөвлөлөөр батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө байгаагүй нь сангийн төсвийг хийхэд зөвхөн БОАЖЯ-ны дунд хугацааны зорилт, арга хэмжээнд тулгуурлан тус онуудын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийн хэмжээг тооцоход хүргэсэн юм.

Цаашид энэ тал дээр харьяа яам, тус сангийн Удирдах зөвлөл анхаарал хандуулах нь Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа бодит байдлаар тусгалаа олох, мөн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу бодит байдлаар голдирлоо олох ач холбогдолтой гэж үзэж байна.

3 2012 оны төсөв

3.1 2012 оны төсөв боловсруулах үйл явц

Цэвэр агаарын сангийн 2012 онд батлагдсан төсөв нь Монгол Улсын Нэгдсэн Төсвийн тухай хууль¹, Төсөвт Байгууллагын Удирдлага Санхүүжилтийн тухай хууль² болон Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах” тухай БОАЖЯ-ны сайдын тушаалын³ дагуу боловсруулагдаж батлагдсан байсан.

Цэвэр агаарын сангийн тухайн жилийн төсвийг боловсруулах үндсэн арга нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нь Цэвэр агаарын сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн санал, өөрийн яам болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурладаг байна.

Ийнхүү боловсруулсан төсвөө төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд өөрийн багцад тусган төлөвлөж, Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг байна.

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Цэвэр агаарын сангийн орлого, зарлагыг холбогдох журмын дагуу хянаж, улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөөнд тусгаж, Төсөвт байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай (энэ тайланд цаашид “ТБУСТ” хууль гэнэ) хуулийн⁴ 31.1-ийн дагуу тухайн жилийн 9-р сарын 15-ны дотор Засгийн Газарт өргөн мэдүүлдэг байна.

Засгийн газар нь төсвийн нэгдсэн төслийн төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч нэг бүрээр хэлэлцэж, ийнхүү хэлэлцсэн төслийг ТБУСТ хуулийн 32.1-д зааснаар УИХ-д өргөн мэдүүлдэг байна.

УИХ нь хууль заасан хугацаанд тухайн жилийн төсвийг баталдаг бөгөөд дээрх үйл явц, дүрэм журмын дагуу Цэвэр агаарын сангийн 2012 оны төсөв нийт 31.0 тэрбум төгрөгөөр батлагджээ. Үүнээс Цэвэр агаарын сангийн дотоод үйл ажиллагааны зардал нь 210 сая төгрөг, үлдэх хэсэг нь тус сангийн, Байгаль орчин аялал жуулчлалын яамны, мөн бусад төрийн байгууллагуудын агаарын бохирдолыг бууруулах ажил, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг санхүүжүүлэх зардал хэлбэрээр батлагдсан байна.

Улаанбаатар Цэвэр Агаар II төслөөс ЦАС-ийн 2012 оны төсвийг тодорхойлохдоо зөвхөн үйл ажиллагааны зардалд нь дүн шинжилгээ хийж, урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг 197.9 сая төгрөгөөг нэмэгдүүлэн нийт 407,7. сая төгрөг байхаар тооцоолсон.

3.2 Төсвийн төсөөллийг боловсруулахад анхаарсан асуудлууд:

2012 оны төсвийг боловсруулахдаа дараах асуудлуудыг анхаарал хандуулсан болно. Үүнд:

¹ 2002 оны 11 сарын 20-ны өдөр батлагдсан

² 2002 оны 06 сарын 27-ны өдөр батлагдсан

³ 2011 оны 06 сарын 15-ны өдрийн тушаал

⁴ 2002 оны 06 сарын 27-ны өдөр батлагдсан

Цэвэр агаарын сангийн төсөв (2012, 2013-2015 он)

1. Хууль, тогтоомжийн хүрээнд нийцүүлэх. Төсөвт байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль⁵, Нэгдсэн төсвийн тухай хууль⁶, Төрийн Аудитын тухай хууль⁷, Төрийн албаны хууль⁸, Тусгай сангийн тухай хууль⁹, “Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох тухай” Засгийн газрын 96-р тогтоол¹⁰, “Мэргэшсэн нягтлан бодогчдод мэргэжлийн нэмэгдэл олгох тухай” Санхүү Эдийн Засгийн Сайдын 258-р тоот тушаал¹¹, “Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” Сангийн Сайдын 132, 124-р тоот тушаалууд¹², Засгийн газрын Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам¹³ болон Цэвэр агаарын сангийн Байгууллагын дотоод журам¹⁴-д тус тус нийцүүлэх бодлого баримталсан.
2. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тус сангийн удирдлага, зохион байгуулалт, дотоод шаардлага, хэрэгцээнд тулгуурласан байх. Төслийн багаас санал болгосон Цэвэр агаарын сангийн бүтэц, зохион байгуулалтыг 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус сангийн дотоод үйл ажиллагааны зардлыг тодорхойлсон. Хөрөнгө оруулалтын болон төслийн зардлын хувьд 2012 оны БОАЖЯ-ны тодорхойлсон хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд уялдуулсан болно.
3. Бодит төсөвтэй харьцуулсан байдал. 2012 оны төсвийн төсөл нь өнгөрсөн оны төсөв, түүний гүйцэтгэлтэй харьцуулах байдлаар зардлын төрөл, дүнг тодорхойлсон болно. Иймд зайлшгүй байж болох зардлын хэрэгцээг харгалзан үзэж зардлыг хэмжээг тооцоолсон.
4. Бодит зах зээлийн ханшид тулгуурлах. Төсвийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардал нь төсөв бэлтгэх үеийн зах зээл дээрх үнийн түвшинд судлагдаж хийгдсэн.

3.3 Дүгнэлт

Улаанбаатар Цэвэр Агаар санаачлага II төслийн багаас гаргасан 31,2 тэрбум төгрөгийн төсөв дээр дурьдсан хууль, тогтоомж, журамд нийцүүлсэн, сангийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэгдэж, УИХ-аас баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө болон зардлыг дэмжин харин сангийн дотоод зардлын хувьд удирдлага, үйл ажиллагааны бүтцийг тодорхойлж, сангийн 2012 оны дотоод үйл ажиллагаанд уялдуулж зардлыг тооцоолж төсөвлөсөн.

Түүнчлэн 2012 төсвийн төсөөлөл нь тус сангийн дараа, дараагийн жилүүдийн төсвийг боловсруулахад суурь болж өгснөөрөө ач холбогдолтой.

⁵ 2002 оны 06 сарын 27-нд батлагдсан

⁶ 2002 оны 11 сарын 20-нд батлагдсан

⁷ 2003 оны 01 сарын 03-нд батлагдсан

⁸ 2002 оны 06 сарын 28-нд батлагдсан

⁹ 2002 оны 06 сарын 29-нд батлагдсан

¹⁰ 1995 оны 06 сарын 15-нд батлагдсан

¹¹ 2002 оны 09 сарын 17-нд батлагдсан

¹² 2011 оны 06 сарын 14 болон 2006 оны 04 сарын 17-нд батлагдсан

¹³ 2011 оны 06 сарын 15-ны өдрийн тушаал

¹⁴ 2011 оны 06 сарын 17-нд батлагдсан

4 2013-2015 оны төсөв

4.1 2013-2015 оны төсөв боловсруулах үйл явц

Цэвэр агаарын сангийн 2013-2015 оны төсөв боловсруулах үндсэн үйл явц нь энэ тайлангийн 3.1-д дурдсан журмын дагуу явагдана. УИХ-аас 2011 оны 11 сарын 23-нд шинэчлэн баталсан “Төсөвт байгууллагын, удирдлага санхүүжилтийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль”-ийн хүчин төгөлдөр болох хугацаанд төсвийн хугацаа хамааралтайг тооцож 2013-2015 оны төсвийг төсөөллийг бэлгэсэн.

УИХ-н 2012 оны сонгуулийн үр дүнд байгуулагдах шинэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд энэхүү төсвийн төсөл өөрчлөгдөх боломжтой.

4.2 2013-2015 оны Төсвийн төсөөллийг боловсруулахад анхаарсан асуудлууд:

2013-2015 оны төсвийн төслийг боловсруулахдаа дараах асуудлуудыг анхаарал хандуулсан болно. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хүрээнд нийцүүлэх. Төсөвт байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль¹⁵, Төсвийн тухай хууль¹⁶, Төрийн Аудитын тухай хууль¹⁷, Төрийн албаны хууль¹⁸, Тусгай сангийн тухай хууль¹⁹, “Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох тухай” Засгийн газрын 96-р тогтоол²⁰, “Мэргэшсэн нягтлан бодогчдод мэргэжлийн нэмэгдэл олгох тухай” Санхүү Эдийн Засгийн Сайдын 258-р тушаал²¹, “Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” Сангийн Сайдын 132,124-р тушаал²², Засгийн газрын Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам²³ болон Цэвэр агаарын сангийн Байгууллагын дотоод журам²⁴ д тус тус нийцүүлэх бодлого баримталсан.
2. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тус сангийн удирдлага, зохион байгуулалт, дотоод шаардага, хэрэгцээнд тулгуурласан байх. Төслийн багаас 2013-2015 оны удирдлага, зохион байгуулалтын 3 төрлийн бүтцийг санал болгосон бөгөөд тус онуудын төсвийг хийхэд 12 ажилтантай байх үндсэн бүтцэд тулгуурлаж, сангийн дотоод зардлыг хэмжээг тодорхойлсон байгаа. Төслийн үйл ажиллагааны зардлыг тодорхойлохдоо УИХ-аас баталсан “Шинэ Бүтээн Байгуулалт” хөтөлбөрт тулгуурлан боловсруулсан БОАЖЯ-ны дунд хугацааны зорилтот төлөвлөгөөнөөс ЦАС-ийн үйл ажиллагааны чиглэл, зорилгод нийцсэн төлөвлөгөөг сонгон авч сангийн ирэх гурван жилийн төлөвлөгөө, зарцуулалтын ерөнхий төсөөлөлийг гаргасан болно.
3. Бодит төсөвтэй харьцуулсан байдал. Төслөөс багаас гаргасан 2012 оны төсвийн төсөөлөл нь 2011 оны төсөв, түүний гүйцэтгэлтэй харьцуулах байдлаар хийгдсэн

¹⁵ 2011 оны 12 сарын 23-нд батлагдсан

¹⁶ 2011 оны 12 сарын 23-нд батлагдсан

¹⁷ 2003 оны 01 сарын 03-нд батлагдсан

¹⁸ 2002 оны 06 сарын 28-нд батлагдсан

¹⁹ 2002 оны 06 сарын 29-нд батлагдсан

²⁰ 1995 оны 06 сарын 15-нд батлагдсан

²¹ 2002 оны 09 сарын 17-нд батлагдсан

²² 2011 оны 06 сарын 14 болон 2006 оны 04 сарын 17-нд батлагдсан

²³ 2011 оны 06 сарын 15-ны өдрийн тушаал

²⁴ 2011 оны 06 сарын 17-нд батлагдсан

Цэвэр агаарын сангийн төсөв (2012, 2013-2015 он)

бөгөөд ийнхүү тодорхойлсон 2012 оны төсвийн төсөөллийг ашиглан 3 жилийн төсвийн төсөөлөл бэлтгэхдээ суурь үзүүлэлт болгон ашигласан.

4. Бодит зах зээлийн ханшид тулгуурлах. Төсвийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийн дүнг гаргахдаа төсөв бэлтгэх үеийн буюу 2012 оны 6-р сарын байдлаар зарлагын төрөл бүрийг зах зээлийн үнийн тодорхойлж хийсэн. Түүнчлэн 2012 оны 4-р сарын 30-ны өдрийн гаргасан Засгийн Газрын “Монгол Улсын 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөлөл”-д тусгагдсан ирэх онуудын эдийн засгийн өсөлтөөс хамааралтай инфляцийн түвшингийн 13.1% гэсэн таамаглалыг тооцоолж, 3 жилийн төсвийн төсөөллийг бэлтгэсэн.

4.3 Дүгнэлт

Төслийн багаас 2013-2015 оны төсвийг хийхэд сангийн хувьд тус онуудад хийгдэх үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөө байгаагүй байсан хэдий ч төслийн баг нь сангийн зорилгод нийцсэн, агаарын бохирдлыг бууруулахад чухал нөлөөтэй хэмээн үзсэн ажлуудыг “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилгод тусгагдсан төлөвлөгөөнөөс сонгон авч сангийн 2013-2015 оны үйл ажиллагааны зардлын хэмжээг 219.3 тэрбум гэж тооцоолсон. Сангийн дотоод зардлын хувьд төслийн багаас санал болгож буй байгууллагын үндсэн бүтцийн хүрээнд тооцоолсон урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг нийтдээ 1.4 тэрбум төгрөг гэсэн төсвийн төсөөллийг гаргасан.

Хэдийгээр Улаанбаатар Цэвэр Агаар II төслөөс сангийн үйл ажиллагааны төсөв болон дотоод зардлын төсвийг тооцоолон гаргасан ч энэхүү төсөөлөл нь УИХ-ын 2012 оны сонгуулийн үр дүнд байгуулагдах УИХ болон шинэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд өөрчлөгдөх, мөн ирэх жилийн улсын төсөвт дээрх дүнгээр батлагдах төсөв биш бөгөөд харин сангийн ирэх оны төсөв бэлтгэх, батлуулахад гарын авлага болох юм.

5 ЗӨВЛӨМЖ

5.1 Төсөв боловсруулахад цаашид анхаарах асуудлууд.

- Агаарын бохирдлыг бууруулах зорилго чиглэл бүхий олон байгууллагууд байгаа бөгөөд эдгээрийн үйл ажиллагааг хооронд уялдуулж нэгдсэн нэг төлөвлөгөө гаргах төсөв боловсруулах нь ач холбогдолтой гэж төслийн багын зүгээс үзэж байгаа болно. Одоогийн байдлаар нэгдсэн төлөвлөгөөг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо боловсруулж байгаа хэдий ч тус хорооны төсвийн зарцуулалтад хяналт тавих зохицуулалт хангалгүй байгаа юм. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх зарим асуудлыг шийдвэрлэсэн тогтоол шийдвэр гаргаж байгаа нь нэгдсэн нэг төлөвлөгөө гаргах шаардлагыг бий болгож байна.
- Хуулийн дагуу бүрдүүлэх орлогыг бүрэн хэмжээгээр Цэвэр агаар сангийн төсөвт тусгасан байх
Цэвэр агаарын сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1.1-д заасан орлогоос бүрдэхээр зохицуулсан байдаг. Одоогийн байдлаар уг орлого бүхэлдээ Цэвэр агаарын санд орохгүй байгаа бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд улсын төсвөөс санхүүжилт авч байна.
- Өмнөх онуудын төсвийн гүйцэтгэлд хийгдсэн төрийн аудит, хяналт шалгалтын дүгнэлтүүдийг үйл ажиллагаандаа анхаарч ажиллах
- Төсөв боловсруулахтай холбоотой хууль, тогтоомжуудийг дагаж мөрдөх

6 Хавсралт

6.1 2012 оны төсвийн төсөөлөл.

Цэвэр агаар сангийн 2012 оны төсвийн хураангуй:

<i>сая.төгрөг</i>	
ТӨСЛИЙН ЗАРДАЛ	ДҮН
Үйл ажиллагааны нийт зардал	30,790.0
Нийт	30,790.0
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛУУД	ДҮН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	
Тээврийн хэрэгсэл	79.0
Тавилга эд хогшил	12.9
Компьютер түүний дагалдах хэрэгсэл	12.5
Тоног төхөөрөмжүүд	3.6
Нийт хөрөнгө оруулалтын дүн	108.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	
1. Хөдөлмөрийн зардал	111.6
2. Шатахуун, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	18.2
3. Томилолтын зардал	56.0
4. Оффисын хангамжийн зардал	2.0
5. Бичиг хэргийн зардал	15.9
6. Харилцаа холбооны зардал	10.2
7. Түрээс болон бусад холбогдох зардал	39.9
8. Сургалт болон хурал, уулзалтын зардал	37.7
9. Бусад зардал	8.2
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	299.8
Ерөнхий үйл ажиллагааны зардлын нийт дүн	407.7
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	31,197.7

Цэвэр агаарын сангийн төсөв (2012, 2013-2015 он)

6.2 2013-2015 оны төсвийн төсөөлөл.

Цэвэр агаар сангийн 2013-2015 оны төсвийн хураангуй:

сая.төгрөг

ТӨСЛИЙН ЗАРДАЛ	2013	2014	2015
Үйл ажиллагааны нийт зардал	99,464.3	64,544.3	55,344.3
Нийт	99,464.3	64,544.3	55,344.3
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛУУД			
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ			
Тээврийн хэрэгсэл	106.3	-	-
Тавилга эд хогшил	-	-	-
Компьютер, түүний эд анги дагалдах хэрэгсэл	-	-	-
Тоног төхөөрөмжүүд	-	-	-
Нийт хөрөнгө оруулалтын дүн	106.3	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
1. Хөдөлмөрийн зардал	153.9	171.9	192.3
2. Шатахуун, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	26.7	30.2	34.2
3. Томилолтын зардал	61.2	69.2	78.2
4. Оффисын хангамжийн болон бичиг хэргийн зардал	17.5	19.8	22.4
5. Харилцаа холбооны зардал	11.5	13.1	14.8
6. Түрээс болон бусад холбогдох зардал	45.1	51.0	57.7
7. Сургалт болон хурал, уулзалтын зардал	51.1	57.8	65.4
8. Бусад зардал	9.3	10.5	11.9
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	376.3	423.5	476.9
Ерөнхий үйл ажиллагааны зардлын нийт дүн	482.6	423.5	476.9
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	99,947.0	64,967.9	55,821.2